



## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Нийгмийн даатгалын сангийн 2025 оны  
төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах  
тухай хуулийн төслийн тухай*

“Монгол Улсын 2025 оны төвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын 1.1 дэх хэсэгт “чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шийдвэрлэх”-ийг Засгийн газарт даалгасан.

Иймээс, бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын орон тоог бууруулах шаардлагатай байна.

Түүнчлэн, Ажилгүйдлийн даатгалын сангийн 2024 оны эцсийн олгогдоогүй тэтгэмж 19.2 тэрбум төгрөгийг 2025 оны эхэнд олгосонтой холбоотойгоор тус сангийн 2025 оны төсөв хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр мөн хэмжээгээр дутахаар байна.

Тэтгэврийн даатгалын сангийн 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэврийн авагчдын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2325 хүнээр буурснаас тус сангийн зарлагад хэмнэлт бий болж байна.

Иймд Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагыг нэмэгдүүлэхгүйгээр сан хооронд зохицуулалт хийх, орлогод өөрчлөлт оруулахаар тооцож төсвийн тодотголын төслийг боловсрууллаа.

---oOo---